

3 ИОХАН

¹ Ахлагчаас үнэн дотор миний хайрладаг хайрт Гайост:

² Хайрт минь, сэтгэл тань амжилттай байгаагийн адил аливаа үйлс тань амжилт олж, эрүүл энх байгаасай хэмээн би залбирч байна. ³ Ах дүү нар ирж, чиний үнэнийг буюу чамайг үнэний дотор хэрхэн явж буйг гэрчилсэнд би маш их баярласан. ⁴ Миний хүүхдүүд үнэн дотор явж байгааг сонсохоос илүү эрхэм баяр баясгалан надад байхгүй билээ.

⁵ Хайрт минь, чи ах дүүгийнхээ төлөө, ялангуяа харь хүмүүсийн төлөө аливааг хийхдээ итгэмжтэй зүтгэж байгаа юм байна. ⁶ Чиний хайрын тухай тэд чуулганы өмнө гэрчилсэн юм. Бурханд зохистой байдлаар тэднийг аян замд нь үдэж байвал чи сайн байх болно. ⁷ Учир нь тэд Харь үндэстнүүдээс юуг ч авалгүй Нэрийн төлөө явцгаасан билээ. ⁸ Гиймээс тэдэн шиг хүмүүсийг бид дэмжих ёстой. Тэгснээр бид үнэний хамтран зүтгэгч болох билээ.

⁹ Би зарим нэг зүйлийг чуулганд бичсэн. Харин тэдний дунд тэргүүн болохыг дурлагч Диотреф биднийг хүлээж авахгүй байгаа юм. ¹⁰ Иймээс хэрэв би очвол, түүний хийдэг үйл хэргийг нь сануулна. Юу гэвэл, тэр биднийг балмад үгсээр зүй бусаар буруутгасан юм. Үүгээр ч сэтгэл ханахгүй, тэр ах дүү нараа хүлээн авдаггүй бөгөөд хүлээн авахыг хүсэгчдийг хориглон, чуулганаас хөөж байна.

¹¹ Хайрт минь, мууг биш, харин сайныг дуурай. Сайныг үйлдэгч нь Бурханых. Мууг үйлдэгч нь Бурханыг хараагүй юм. ¹² Деметр хүн бүрээс болон үнэнээс өөрөөс нь гэрчлэлийг хүлээн авчээ. Бид ч бас гэрчилнэ. Бидний гэрчлэл үнэн гэдгийг чи мэднэ.

¹³ Бичих зүйл надад олон байгаа боловч би бийр янтай нийлүүлэн чамд бичихийг хүсэхгүй байна. ¹⁴ Харин чамтай удахгүй уулзана гэдэгтээ найдаж байна. Бид нүүр нүүрээрээ учран ярилцах болно. ¹⁵ Амар тайван нь чамд байг. Чамд анд нөхөд чинь мэнд хүргэж байна. Анд нөхдөд нэрээр нь мэнд хүргээрэй.